



**“БУЛИГААР” ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

<i>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт I/</i>		
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>		
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Булигаар” ХК РД:2039184 MSE: MBG Утас: 99626299 И-мэйл: info@buligaar.com Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг 17042, Чингисийн өргөн чөлөө, АШҮ-н хашаа	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Арьс шир боловсруулалт Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Сэрэлт дөл аудит” ХХК 2019-08-28	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	400,212,000	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Н.Тэмүүжин ТУЗ-ийн нарийн бичиг Г.Цээпилжид Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан <i>/хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн: 16,346,563,015.65 Эргэлтийн бус хөрөнгийн дүн: 18,987,377,031.14 Нийт хөрөнгийн дүн: 35,333,940,046.79 Өр төлбөрийн нийт дүн: 24,454,875,811.37 Эздийн өмчийн дүн: 10,879,064,235.42 Өр төлбөр ба эздийн өмчийн дүн: 35,333,940,046.79
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого: 8,991,446,032.19 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: 7,584,464,374.43 Нийт ашиг: 1,406,981,657.76 Бусад орлого: 0.00 Борлуулалт, маркетингийн зардал: 0.00 Ерөнхий ба удирдлагын зардал: 1,001,929,442.86 Бусад зардал: 7,993,800.00

		Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-53,476,377.26
		Татвар төлөхийн өмнөх ашиг:	343,582,037.64
		Орлогын татварын зардал:	40,586,776.56
		Тайлант үеийн цэвэр ашиг:	302,995,261.08
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	11,727,544,902.86
		2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	11,662,764,191.94
		2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	12,966,912,712.75
		2025 оны тайлант үеийн цэвэр ашиг:	302,995,261.08
		2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	12,870,712,691.93
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн орлогын дүн:	10,116,135,610.48
		Мөнгөн зарлагын дүн:	11,182,491,263.12
		Үндсэн үйл ажиллагааны	
		Мөнгөн гүйлгээ:	-1,066,355,652.64
		Мөнгөн орлогын дүн:	0.00
		Мөнгөн зарлагын дүн:	1,518,225,317.31
		Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	-1,518,225,317.31
		Мөнгөн орлогын дүн:	4,720,000,000.00
		Мөнгөн зарлагын дүн:	2,106,927,380.01
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	2,613,072,619.99
		Валютын хашийн зөрүү:	-2,549,273.57
		Цэвэр мөнгөн гүйлгээ:	25,942,376.47
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл:	14,182,297.87
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл:	40,124,674.34
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт		
	“Сэрэлт дөл аудит” ХХК нь “Булигаар” ХК-ийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн МУ-ын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.		
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/		
	Энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.		

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн	Санхүүгийн үзүүлэлтүүд БУЛИГААР ХК 2025 ОН /2024 оны гүйцэтгэлтэй харьцуулав/ ↑ 4.2% 8.99 тэрбум төгрөг Борлуулалтын орлого ↑ 317% 302.9 сая төгрөг Цэвэр ашиг ↑ 22% 8.99 тэрбум төгрөг Дотоод борлуулалт ↑ 9.9% 245.7 дм.кв Бодын арьсны дундаж талбайн хэмжээ /Монгол/ ↑ 6.3% 501.29 төгрөг /Нэгж дм.кв арьсны үнэ/ Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дундаж үнэ Нийт борлуулалтын орлого /тэрбум,төгрөг/ 5.406 7.206 75% 7.381 8.628 85% 7.584 8.991 85% 2023 2024 2025 Борлуулалтын өртөг Борлуулалтын орлого Борлуулалтын орлого дахь борлуулалтын өртгийн эзлэх хувь Экспортын борлуулалтын орлого /тэрбум ₮/ 1,465 0 1,000 2024 2025 2026 Цэвэр ашиг (алдагдал) /сая, төгрөг/ 35.2 95.5 302.99 2023 2024 2025 Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ 33.9 32.5 35.3 2023 2024 2025

		Хөрөнгө оруулалт
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 0.86% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 2.79% Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/ Нийт активын өөрчлөлт 1.089 % Зээлийн багцын өөрчлөлт 1.14% Хөрөнгөд эзлэх хувь Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө 0.31% Өр төлбөр /Нийт хөрөнгө 0.69% Хөрвөх чадварын харьцаа Хөрвөх чадварын хөрөнгө/ 46.2% Татан төвлөрүүлсэн хөрөнгө 69.2%
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	ТУЗ-ийн баталсан 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан ашгийн түвшинг нэмэгдүүлэх, дотоод борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн харилцагчид илүү ойртож ажиллах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг баримтлан ажиллах, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн. 2025 онд санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд 13 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй байснаас бодит гүйцэтгэлээр 9,886.3 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөөг 71%-ийн биелэлтэй ханган ажилласан байна. Монгол Улс дахь дотоод борлуулалт өмнөх оны мөн үеэс 22%-ийн өсөлтийг үзүүлсэн. - Гадаад борлуулалт хийгдээгүй байна. Манай үйлдвэрийн болон манай улсын арьс ширний салбарын гол эрэлтийг үүсгэдэг БНТУ, БНХАУ, Итали улсуудад мөн арьс ширний салбар төдийлөн сайн биш ажилласны улмаас, түүнчлэн манай Монгол улсаас бэлтгэн нийлүүлэгдэж байгаа дотоодын түүхий эдийн чанар шаардлага дэлхийн стандартад хүрэхгүй байгаа шалтгаанаас болж буурсан байна. - Ижил төрлийн бүтээгдэхүүний хяналтгүй импортын эсрэг үйлдвэрлэлийн технологийг тогтвортой байлгах, шинэчлэлт хийх бодлого барьж ажиллаж байгаа.

		- Мэргэжлийн болон менежментийн ур чадвар бүхий ажиллах хүчний тасалдал бий болсон төдийгүй энэ байдал цаашид үргэлжлэх хандлагатай байна. Энэхүү асуудал нь салбар төдийгүй улсын хэмжээнд яригдах болсон. Булигаар компанийн хувьд 2025 онд 113,521 үхрийн шир, 10 мянган ямааны арьсыг хагас болон гүн боловсруулан дотоодын зах зээлд нийлүүлсэн байна. 2025 онд нийт хөрөнгө оруулалтын 96.8%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжид, 3.2%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтад зарцуулсан байна. Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах дэвшилтэт технологи, тогтвортой хөгжлийн бодлогыг мөрдөн ажилладаг бөгөөд эрчим хүч болон бусад байгалийн нөөцийг хэмнэх, цаашлаад хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх чиглэлд хөрөнгө оруулалтуудыг тасралтгүй хийсээр байна. Энэхүү ажлын хүрээнд: - БНХАУ-ын “Yancheng” Shibao компаниас 20 тонн түүхий эд ачаалах хүчин чадал бүхий 2 ширхэг даацын барбан худалдан авч суурилуулсан. - Итали улсын “СМ” компаниас орчин үеийн технологийн шийдэл, давуу талуудыг өөртөө бүрэн агуулсан сунгах машин - БНХАУ-ын Brenu Industry компаниас хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмжийг өсгөх чиглэлд 282 метр дамжуургын шугам; - БНХАУ-ын “СНМ” компаниас халимлах машины өөх тос шахах, хусах дамжлагын зоргодос дамжуурга, шохойн барбанд үс шүүх систем зэрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангаж зардал хэмнэх тоног төхөөрөмжүүдийг авч суурилуулсан. Ирж буй 2026 ондоо хүний нөөцийн чадавхыг улам бүр сайжруулах чиглэлд анхаарч мэдлэг ур чадварт тулгуурласан бүтээлч хамт олны соёлыг цогцлоож салбарын тэргүүлэгч үйлдвэрүүд болохыг зорин ажиллаж байна.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Цагаан Алт хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр 2025.04.01-ний өдөр Капитрон банкт байгуулсан эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн барьцаанд компанийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг тус тус барьцаалсан байгаа.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Сүүлийн хэдэн жил ТУЗ-ийн ердийн гишүүдэд цалин олгохгүй бөгөөд хараат бус гишүүдийн цалин нь хурлын оролцоонд үндэслэсэн цалинтай байдаг. 2025 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.

ТУЗ-ийн хараат бус гишүүдэд олгох оролцоонд суурилсан цалин

ТУЗ-ийн хурал,
Хувьцаа эзэмшигчдийн хурал,
ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоо тутамд
250,000 төг

ТУЗ-ийн цалин урамшуулал	2024 он		2025 он
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
Оролцооны цалин	7,500,000	7,500,000	9,000,000
Нийт дүн	7,500,000	7,500,000	9,000,000

2025.04-2026.04 хүртэлх хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд хуралд оролцсон оролцооноос хамааран 9,0 сая төгрөгийн цалинг олгоно гэж төсөвлөсөн байгаа. Компанийн гүйцэтгэх удирдлагын цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг ТУЗ-аас гүйцэтгэх удирдлагатай байгуулах “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний холбогдох заалтад тусгасан байгаа.

Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг бөгөөд цалин урамшуулал нь компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ажлын гүйцэтгэлтэй уялдсан байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ, түүнийг олгох зарчмыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо тогтоодог. 2024 оны 4-р сард шинээр томилогдсон Гүйцэтгэх захиралтай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн байгуулан мөрдөн ажиллаж байна.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 13:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав.

Хурлын ирц: Хуралд 88.13 хувийн саналын эрхтэй нийт 10 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан.

Хурлаар танилцуулан хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Булигаар ХК-ийн 2024 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “хангалттай” гэсэн дүгнэлт өгснийг 99.9%-ийн саналаар батлав.
- Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулав.
- 2024 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулж, 99.9%-ийн саналаар батлав.
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг танилцуулан, ТУЗ-ийн гишүүдийг 1 жилийн хугацаагаар сонгов.



ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат танилцуулав.



Компанийн аудитын тайланг “Сэрэлт дөл аудит” ХХК-ийн аудитор Д.Алтанцэцэг танилцуулав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн 2025.04.18-ны өдрийн ээлжит хурлаар 1 жилийн хугацаагаар сонгогдсон бөгөөд тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллав. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн:

1. Төмөрбаатар овогтой Болд
2. Чулуунбаатар овогтой Нямдорж
3. Жадамба овогтой Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн:

1. Батчулуун овогтой Анхболд
2. Батчулуун овогтой Баянжаргал
3. Анхболд овогтой Энхмэнд
4. Довжид овогтой Гансүх
5. Бямбабаяр овогтой Баттүшиг
6. Цэрэндагва овогтой Мөнхлхагва

“Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг батлан, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ирц: ТУЗ-ийн дэргэд 3 хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

№	Хуралдсан огноо	Тогтоолын дугаар	Тогтоолын тухай
1	2025.01.10	01/25	Эрх олгох тухай
		02/25	Эрх олгох тухай
2	2025.02.17	03/25	Ногдол ашгийн тухай
3	2025.02.24	04/25	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
4	2025.03.18	05/25	Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай
5	2025.07.02	06/25	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай
		07/25	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай

Тайлант хугацаанд ТУЗ нь хороодын оруулж ирсэн санал, дүгнэлтийн дагуу дараах хэлэлцэх асуудлын хүрээнд 5 удаагийн хуралдаанаар ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулсан. Тус хугацаанд нийт 7 тогтоолоор шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. ТУЗ-ийн хурлыг танхимаар, цахимаар, эчнээгээр зохион байгууллаа.

ХОРООДЫН ТОГТООЛ, ШИЙДВЭР

№	Хороод	Хуралдсан огноо	Дүгнэлт, тогтоолын дугаар	Агуулга
1	Аудитын хороо	2025.01.10		Эрх олгох тухай
2	Аудитын хороо	2025.02.17		Ногдол ашгийн тухай
3	Аудитын хороо	2025.03.18		Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай
4	Нэр дэвшүүлэх хороо	2025.04.14		ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэгчийн талаар
5	Цалин урамшууллын хороо	2025.04.14		ТУЗ-ийн цалин урамшуулал, зардлын талаар

ТУЗ БОЛОН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛДААН

<i>Хурал</i>	<i>Ээлжит хурал</i>	<i>Ээлжит бус хурал</i>	<i>Хэлэлцсэн асуудал</i>	<i>Шийдвэр, дүгнэлт</i>	<i>Санал зөвлөмж</i>	<i>Баталсан тогтоол</i>
ТУЗ-ийн хурал	4	1	7			7
Аудитын хороо	2	1	4	3	1	
Цалин урамшууллын хороо	1		1	1		
Нэр дэвшүүлэх хороо	1		1	1		

ХУРЛЫН ИРЦ

ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, биечлэн оролцох боломжгүй тохиолдолд саналаа цахим шуудангаар урьдчилан илгээдэг. Ийм тохиолдол цөөн бөгөөд хурлын ирцийг оролцсоноор тооцдог.

<i>ТУЗ-ийн гишүүний нэр</i>	<i>ТУЗ-ийн хорооны харьяалал</i>	<i>ТУЗ-ийн хурлын ирц</i>	<i>ТУЗ-ийн Хорооны ирц</i>
Т.Болд	Нэр дэвшүүлэх хорооны дарга	100%	100%
	Аудитын хорооны гишүүн		
Ч.Нямдорж	Аудитын хорооны дарга	100%	100%
Ж.Эрдэнэбат	Цалин урамшууллын хорооны дарга	100%	100%
Б.Баянжаргал	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
Б.Баттүшиг	Аудитын хорооны гишүүн	100%	100%
Д.Гансүх	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
Б.Анхболд	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
А.Энхмэнд	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
Ц.Мөнхлхагва	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%

Компани нь сайн засаглалын туршлагаудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч байгаа. Энэхүү зарчмын хүрээнд 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичиг бүхий тараах материалыг 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад цахимаар хүргүүлсэн.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2025 онд ТУЗ-ийн үйл ажиллагаанд 18,221,700 төгрөгийн зардал (2025.04.18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 02/25 тоот тогтоол) төсөвлөж, гүйцэтгэл 12,402,000 төгрөг буюу 68%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2025 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл дараах хүснэгтээс үзнэ үү.

<i>Зардлын төрөл</i>	<i>2024 он</i>		<i>2025 он</i>
	<i>Гүйцэтгэл</i>	<i>Төлөвлөгөө</i>	<i>Гүйцэтгэл</i>
ТУЗ-ийн цалин урамшуулал	7,500,000	9,000,000	3,750,000
ХЭ-ийн хурлын зардал	2,103,800	2,121,700	2,490,000
Бусад зардал /Үйлчилгээний хураамж/	4,500,000	7,100,000	6,162,000
Нийт дүн	14,103,800	18,221,700	12,402,000

Жич: Энэхүү төсөв нь 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа жилийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

Тус компанийн ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгийг хүсэлтийн дагуу үүрэгт ажлаас чөлөөлж, 2025.08.14-ний өдрөөс эхлэн Булигаар ХК-ийн ерөнхий нягтлан бодогчоор Н.Тэмүүжинг томилохоор шийдвэрлэсэн.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:

- Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг
Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа: 7 жил
Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил: 0.002%
- Ерөнхий нягтлан бодогч Н.Тэмүүжин
Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа: 7 жил
Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.

УЛИРАН СОНГОГДСОН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд:

1. Төмөрбаатар БОЛД

Боловсрол

1987 – 1992 он ЗХУ-ын Украины Машин байгууламжийн дээд сургууль, Инженер

Ажлын туршлага

1992 – 1995 он Монголын хөрөнгийн бирж, Хяналтын ажилтан
1995 оноос Дэлгэрхангай брокерийн пүүс, Брокер
2017 оноос Даац инвестмент ХХК, Гүйцэтгэх захирал
2017 оноос Монголын Үнэт цаасны бирж, ТУЗ-ийн ердийн гишүүн
2021 оноос Тэлмэн групп ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн
2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

2. Чулуунбаатар НЯМДОРЖ

Боловсрол

1988 – 1992 он Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Нягтлан бодогч, эдийн засагч
1997 – 2000 он Монгол Улсын Их Сургууль, Эрх зүйч
2003 он Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

1992 – 1993 он ШУА-ын харьяа Хөдөө Аж Ахуйн Эдийн засгийн хүрээлэн, Эрдэм шинжилгээний ажилтан
1993 – 1995 он Чингэлтэй дүүргийн Татварын алба, ТУБ
1995 – 2014 он Төрийн хянан шалгах хороо, Нийслэлийн аудитын газар, Хянан байцаагч, ахлах хянан байцаагч, ахлах шинжээч
2014 – 2020 он Одбүртгэл аудит болон Мүүрь Аудит ХХК, Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан дэд захирал
2021 оноос Тэргэл менежмент ХХК, Гүйцэтгэх захирал
2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

3. Жадамба ЭРДЭНЭБАТ

Боловсрол

1987–1992 он Монгол Улсын Их Сургууль, Математикч

Ажлын туршлага

1992 – 1996 он Монгол Улсын Их Сургуулийн ТИС, Багш
1996 – 2001 он Ноён суудал брокерын пүүс, Гүйцэтгэх захирал
2002 – 2004 он Ханын материал ХК, Санхүү эрхэлсэн захирал
2013 – 2016 он Хөдөө аж ахуйн бирж, Гүйцэтгэх захирал
2017 – 2020 он Монголын Үнэт цаасны бирж, Гүйцэтгэх захирал
2020 – 2022 он Эрдэс баялгийн бирж, Гүйцэтгэх захирал
2022 оноос Тэргэл менежмент ХХК, Шинжээч ажилтан
2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд:

4. Батчулуун АНХБОЛД

Боловсрол

1990 – 1994 он Монгол Улсын Их Сургууль, Худалдааны эдийн засагч
1995 – 1996 он Монгол Улсын Их Сургууль, Мэдээлэл зүйн магистр

Ажлын туршлага

1994 – 1996 он МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Мэдээлэл зүйн багш
1998 – 2000 он Санком ҮЦК ХХК, Диллер
2001 – 2018 он Дархан Минж ХХК, Ерөнхий захирал, гүйцэтгэх захирал
2019 – 2024 он Булигаар ХК, Гүйцэтгэх захирал
2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

5. Батчулуун БАЯНЖАРГАЛ

Боловсрол

1996 – 2000 он Монгол Улсын Их Сургууль, Эдийн засагч

Ажлын туршлага

2000 – 2006 он Монгол шуудан банк, Нягтлан бодогч
2006 оноос Дархан Минж ХХК, Гүйцэтгэх захирал, дэд захирал
2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

6. Анхболд ЭНХМЭНД

Боловсрол

2013 – 2016 он ИБУИНВУлсын Вестминстерийн Их Сургууль, Хөрөнгө оруулалтын санхүүч

Ажлын туршлага

2016 – 2017 он Монголын үнэт цаасны бирж ХХК, Төлбөр тооцооны ахлах ажилтан
2017 он Ард секюритиз ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын аналитист
2018 он Монгол шир төсөл, Парк таун бонд, Санхүүгийн зөвлөх
2018 – 2019 он Екап ХХК, Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалт хариуцсан захирал
2020 – 2021 он Лугати ХХК, Гүйцэтгэх захирал
2021 – 2022 он Мөнх Орших Капитал ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал
2022 оноос Алтан Хоромсог үнэт ҮЦК ХХК, Гүйцэтгэх захирал
2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн дарга**

7. Довжид ГАНСҮХ

Боловсрол

1986 – 1991 он ОХУ-ын Барилгын Их Сургууль, Барилгын технологич

Ажлын туршлага

1993 – 1995 он ТТҮБ траст ХХК, Барилгын даамал

1995 – 2004 он Зэндмэнэ инвест ХХК, Гүйцэтгэх захирал

2004 – 2013 он Дархан Минж ХХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал,
Үйлдвэрлэлийн менежер

2014 – 2018 он Сүлд Ивээл Констракшн ХХК, Захирал

2019 – 2024 он Булигаар ХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал

2024 оноос Нихон инвест ХХК, Гүйцэтгэх захирал

2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

8. Бямбабаяр БАТТҮШИГ

Боловсрол

2012 – 2016 он БНТУ-ын Эге их сургууль, Арьс шир боловсруулах инженер

2016 – 2018 он Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Санхүүгийн
удирдлагаар магистр

Ажлын туршлага

2016 – 2019 он Монгол Шевро ХК, Технологич

2019 – 2024 он Булигаар ХК, Технологич

2024 оноос Булигаар ХК, Гүйцэтгэх захирал

2023 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

9. Цэрэндагва МӨНХЛХАГВА

Боловсрол

2001 – 2005 он Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн КтМС,
Бизнесийн удирдлага

2006 – 2007 он Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн КтМС,
Хүний нөөцийн менежментээр магистр

Ажлын туршлага

2005 – 2007 он МАТ ХХК, Менежер

2007 – 2008 он Гангар Инвест ХХК, Хүний нөөцийн менежер

2008 – 2016 он Алтайн Хүдэр ХХК, Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн,
хэлтсийн захирал

2016 – 2018 он ТМГ групп, Хүний нөөцийн зөвлөх

2019 – 2025 он Булигаар ХК, Хүний нөөцийн ахлах менежер

2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсан дагуу Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодекст нийцүүлэн шинээр болон шинэчлэн баталж үйл ажиллагаандаа даган мөрдөн ажиллаж байна. Тус үнэлгээ нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.7%-тай үнэлэгдэж байсан бол 2025 оны эхний хагас жилийн үнэлгээгээр 93.1%-ийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оны үнэлгээнээс 1.5%-иар өсч 5-р байранд жагсав. “Компанийн засаглалын кодекс” нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг тул компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлийг хангахын тулд хүчин зүтгэлээ гарган ажиллах болно.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2024.12.31		2025.06.30	
			СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээ- ний хувь	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээ- ний хувь
1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100.0%	11	91.7%
2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100.0%	10	100.0%
3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4	66.7%	4	66.7%
4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83.3%	6	100.0%
5.	Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%	8	100.0%
6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100.0%	6	100.0%
7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75.0%	7	87.5%
8.	Компанийн соёл	6	6	100.0%	6	100.0%
9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90.0%	9	90.0%

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮНЭТ ЦААСНЫ АНГИЛЛЫН ШИНЭЧЛЭЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025.09.25-ны өдрийн А/358 тоот тушаалаар хувьцаат компаниудын 2024, 2025 оны үзүүлэлтийг харгалзан үнэт цаасны ангиллыг шинэчлэн тогтооход “Булигаар” ХК нь III ангилалаас II ангилал руу дэвшсэн байна.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Тайлант хугацаанд дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ руу тус тус илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2024 оны санхүүгийн жилийн тайлан
- 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2024 оны компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан
- 2025 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах болсон тухай мэдэгдэл
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, хурлын тэмдэглэл,
- 2025 оны хагас жилийн санхүүгийн жилийн тайлан
- 2025 оны компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажилт
- ХЭ-ийн хурал болон ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг www.mse.mn сайтад байршуулсан.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндлэх бөгөөд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, баримтлах стратегийн бодлогын бичиг баримтыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.


- Одоогоор оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд компанийн ёс зүйн дүрэм болон шүтэл хүлээх журмыг батлан мөрдөж, ажиллаж байгаа.
- “Булигаар” ХК нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааг идэвхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцах хүсэлтэй оролцогч талуудын хүсэлтийг хүлээн авч үйлдвэрийн онцлог, компанийн үйл ажиллагааг нээлттэй танилцуулдаг.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025.04.18-ны өдөр болсон ба хурлыг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу амжилттай зохион байгуулж, хурлын талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлсэн.
- Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй 53 брокер, дилерийн компаниуд руу цахим хэлбэрээр 2025.04.18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичиг бүхий тараах материалыг хүргүүлж танилцуулсан.

Оролцогч талуудаас компанид мэдээлэл хүргэх хэлбэр:

1. Цахим хэлбэрээр илгээвэл, info@buligaar.com гэсэн цахим хаягаар;
2. Бичгээр хэлбэрээр ирүүлбэл, ТУЗ-ийн нарийн бичигт хүргүүлэх;
3. Шуудангаар илгээвэл, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо АШҮХ, Булигаар ХК-ийн байр, 2-р давхарт гэсэн хаягаар;
4. Биечлэн уулзах;

“ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД МОНГОЛЫН АРИЛЖААНЫ БАНКНУУДЫН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ТАНИЛЦУУЛАВ.

Тайлант хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй арилжааны 10 банкны төлөөлөл бүхий 50 хүн, Зээлийн батлан даалтын сангийн 20 хүнийг хүлээн авч хүрээнд компанийн үйл ажиллагаатай биечлэн нээлттэй танилцуулах ажлыг зохион байгуулсан.



6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл				
	Геополитикийн асуудлаас үүдэн дэлхийн болон дотоодын зах зээл дээр түүхий эдийн үнэ, тээврийн зардал ихээр өсөж, цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдэж, гадаад валютын ханшны өсөлт нь валютаар худалдан авдаг бүх бараа материал, үйлчилгээний үнэд нөлөөлж, улмаар компанийн ашигт ажиллагаа буурах, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж, бидний үйлдвэрлэл үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд байгаа. Үүнээс гадна ижил төрлийн бүтээгдэхүүний хяналтгүй импортлогдон орж ирж, дотоодын зах зээл зарагдах болсон.				
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/				
	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 400,212,000 үүнээс 5 ба түүнээс дээш хувийг 3 хувьцаа эзэмшигч буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд:				
	<i>Нэр</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Хувь</i>		
	А.Энхмэнд	156,630,000	39.14%		
	Б.Анхболд	145,996,000	36.48%		
	Б.Баянжаргал	50,000,000	12.49%		
	Бусад 849 хувьцаа эзэмшигч	47,586,000	11.89%		
	Нийт дүн	400,212,000			
	Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно.				
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>				
	2025 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.				
9.	Ногдол ашгийн мэдээлэл				
	Компани нь 2025 онд санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадамжтай байх гэсэн Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1 дэх заалтыг хангаагүй тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй болно.				
	<i>Он</i>	<i>Хувьцааны тоо /ширхэг/</i>	<i>Нэгж хувьцааны ногдол ашиг</i>	<i>Нийт ногдол ашгийн дүн</i>	<i>Ногдол ашиг тараалт</i>
	2020	400,212	-	-	ҮЦТХТ-өөр зуучлуулан 100% тараасан.
	2021	400,212	600 төг	240,127,200	
	2022	400,212,000	0.25 төг	100,053,000	
	2023	400,212,000	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
	2024	400,212,000	-	-	
	2025	400,212,000	-	-	
	<i>Он</i>	<i>Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)</i>	<i>Нийт ногдол ашгийн дүн</i>	<i>Ногдол ашиг тараалтын харьцаа (DPR)</i>	<i>Ногдол ашгийн өгөөж (Dividend yield)</i>
	2021	600 төг	240,127,200	62%	6%
	2022	0.25 төг	100,053,000	23%	2%
	Ногдол ашиг тараалтын харьцаа (DPR): Цэвэр ашгийн хэдэн хувийг ногдол ашиг болгон тарааж буйг илтгэнэ. Ногдол ашгийн өгөөж (Dividend yield): Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг нь нэгж хувьцааны ханишийн хэдэн хувийг эзэлж байгаагаар хэмжигдэнэ.				

**БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН
“МОНГОЛ-ТУРКИЙН БИЗНЕС ФОРУМ-Д АЖИЛТТАЙ ОРОЛЦОВ.**

1. БНТУ-ын Анкара, Истанбул хотуудад Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын зохион байгуулсан Монголын аж ахуй нэгжүүд, бизнесийн төлөөллийн гадаад харилцаа, түншлэл, хамтын ажиллагааны цар хүрээг тэлэх, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, гадаад хөрөнгө оруулалтыг татах зорилго бүхий “Монгол-Туркийн бизнес форум”-д Булигаар ХК-ийн төлөөлөл амжилттай оролцлоо.

Тус Бизнес Форумын үеэр БНТУ-ын “Бурса” аж үйлдвэрийн паркийн арьс шир боловсруулах үйлдвэрийн бүсийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс гарч буй бохир усыг хэрхэн байгальд ээлтэйгээр цэвэршүүлэх “Цэвэрлэх байгууламж”-ын технологи ажиллагаатай танилцан, мөн БНТУ-ын “Гэрэдэ” аж үйлдвэрийн паркийн арьс ширний боловсруулах үйлдвэрүүдийн паркийн менежмент, хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэх, туршлага судлах, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын менежментийн чиглэлээр үйл ажиллагаатай нь танилцан туршлага судлан ажиллалаа.



**БУЛИГААР ХК НЬ GISMA 2025 ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНД
АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ.**

2. 2025 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд БНХАУ-ын Гуанжоу хотноо зохион байгуулагдсан “GISMA 2025” буюу Guangdong International Intelligent Shoe Machine Equipment Exhibition олон улсын үзэсгэлэнд Монгол Улсын арьс ширний салбарын төлөөлөл “Булигаар” ХК болон “Дархан нэхий” ХК-иуд хамтран амжилттай оролцлоо.

Тус үзэсгэлэнд Монгол Улсаас гутал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 40 гаруй үйлдвэр, бизнес эрхлэгчид оролцож байгаа нь онцлог бөгөөд салбарын хөгжил, олон улсын туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.



БНТУ БОЛОН ХБНГУ-ЫН АРСЬ ШИРНИЙ МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ ХАМТРАН ТУРШИЛТ СУДАЛГААНЫ АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

3. БНТУ-ын СІНАН КІМҮА болон ХБНГУ-ын GREIBO CHEMIE компаниудын арьс ширний мэргэжилтнүүдтэй хамтран Монголын арьс ширний үйлдвэрийн технологич нар шинэ технологи хөгжүүлэх, одоо үйлдвэрлэж буй нэр төрлөө дараагийн шатанд гаргах, шинэ нэр төрлийн химийн материалуудтай танилцах туршилт судалгааны ажлыг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээ нь сүүлийн үеийн дэвшилтэт будаг тослогоо болон өнгө заслын химийн материал, технологитой танилцахаас гадна Монгол арьсны онцлогт тохирох оновчтой шийдлүүдийг хамтдаа эрэлхийлсэн цогц туршилт, судалгааны ажил боллоо. Мөн түүхий эдийн гэмтэлтэй холбоотойгоор хонь, ямааны арьс үнэгүйдэж байгааг үйлдвэрлэлд оруулж, дараах үр дүн гарна гэж үзлээ.

- Хонь, ямааны арьсаар хүүхдийн гутлын дээд биений болон дотрын арьс хийх
- Бэлэн болсон хүүхдийн гутлын дээд биений арьсаар гутал үйлдвэрлэх
- Монгол хүүхдийн эрүүл ахуйд нийцсэн арьсан гутлыг дотоодын зах зээлд нийлүүлж, импортыг орлох бүтээгдэхүүн бий болно
- Хонины арьсыг эргэлтэд оруулж, нэмүү өртөг шингээх зорилгоор туршилтын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр ажиллаж эхэлжээ.



2025 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД


4. **НОГООН БАЙГУУЛАМЖ.** Булигаар ХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдлээ. Энэхүү ажлын хүрээнд манай компанийн нийт ажилтнуудын оролцоотойгоор Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Инчон Мөрөөдлийн төгөл” цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг шинэс мод тарилаа. Түүнчлэн байгууллагын хэмжээнд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхээр зүлэгжүүлэлт хийв.



5. **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ.** Орчны хяналт шинжилгээний дагуу хөрс, агаарын мониторинг хийгдэв.
- Хөрсний шинжилгээг MNS5850:2019 стандартад нийцүүлэн хийсэн шинжилгээний үр дүнгээр хөрс нь стандартад нийцсэн хэвийн үзүүлэлтийг хангав.
 - Агаарын шинжилгээг MNS4585:2016 стандартын дагуу үзүүлэлтүүдийг хянаж зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлтийг хангав.
 - Ундны усны шинжилгээг MNS9000:2018 стандартад нийцүүлэн хийсэн шинжилгээний үр дүнгээр унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй байсан.

7. Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах дэвшилтэт технологи, тогтвортой хөгжлийн бодлогыг мөрдөн ажилладаг бөгөөд эрчим хүч болон бусад байгалийн нөөцийг хэмнэх, цаашлаад хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх чиглэлд хөрөнгө оруулалтуудыг тасралтгүй хийсээр байна. Энэхүү ажлын хүрээнд:

- БНХАУ-аас Yancheng Shibao компаниас 20 тонн түүхий эд ачаалах хүчин чадал бүхий 2 ширхэг даацын барбан мөн БНХАУ-ын “Brenu Industry” компаниас хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмжийг өсгөх чиглэлд 282 метр дамжуургын шугам авч суурилуулсан.



- БНХАУ-ын “СНМ” компаниас халимлах машины өөх тос шахах, хусах дамжлагын зоргодос дамжуурга, шохойн барбанд үс шүүх систем зэрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангаж зардал хэмнэх тоног төхөөрөмжүүдийг авч суурилуулсан.



- Итали улсын “СМ” компаниас орчин үеийн технологийн шийдэл, давуу талуудыг өөртөө бүрэн агуулсан сунгах машин мөн вакуум насос хөргүүрийн цамхаг зэрэг тоног төхөөрөмжийн шинэчлэлтүүдийг хийсэн.



8. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил тутам хамруулдаг. 2025 оны 5-р сард Энэрэлт манал эмнэлэгтэй хамтран 60 гаруй ажилтныг үзлэг шинжилгээнд хамруулсан. 2026 онд үзлэгт хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Баттүшиг
Албан тушаал: “Булигаар” ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

BULIGAAR JSC
BULIGAAR
ХК
(Тамга тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Тэмүүжин
Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

(Signature)

Овог, нэр: Г.Цэпилжид
Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичиг

Гарын үсэг:

Г.Цэпилжид